

Өглөөний мэнд,

- “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Түмэнцогт
- хүндэт зочид;
- энэхүү арга хэмжээний эрхэм зочид болох Монголын ханган нийлүүлэгчид ээ;

Та бүхнийг “Оюу толгой”-н Ханган нийлүүлэлтийн форумд хүлээн авч, зочлох завшаан тохиолдсонд миний бие туйлын баяртай байна.

Өнөөдөр “Оюу толгой”-н хувьд чухал өдөр.

Өнөөдөр бид өнгөрсөн жилүүдийн ололт амжилтаа дүгнэн бататгаж, ирэх жилүүдийн өндөр босгоо тогтоох онцгой цаг хугацаа юм.

Хэдий миний бие “Оюу толгой”-д ажиллаж эхлээд удаагүй боловч Монгол Улсын иргэний хувиар миний сэтгэл зүрхэнд “Оюу толгой” төсөл томоохон орон зай эзлэх болоод уджээ.

Монгол Улсын гадаад харилцааны салбарт хүчин зүтгэсэн сүүлийн 20 гаруй жил, Монгол Улсын хөгжил дэвшил, бүтээн байгуулалтыг “Оюу толгой”-гоор төлөөлүүлдгийг харж, мэдэрч ирсэн.

Монгол Улсаа гадаадад төлөөлөн сүүж байсан элчин сайдын хувиар, “Оюу толгой” компаниас Монгол Улсаа төлөөлөн дэлхийн тавцанд гарч ирэхийг ойроос ажиглан харах завшаан тохиосон.

Өнөөдөр, энэхүү компанийн нэг хэсэг болж, ‘аюулгүй ажиллагааг эрхэмлэж, дэлхийд өрсөлдөхүйц зэсийн үйлдвэрлэлийг цогцлоож, Монгол улсын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах’ эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд гар бие оролцох болсондоо баяртай байна.

Урт холын аянд мордохын өмнө, туулсан замаа эргэн нэг харцгаая.

Томоохон төслүүдийн нэгэн адил “Оюу толгой”-н туулсан зам дардан байгаагүй. Гэвч Монгол Улсын хувьд “Оюу толгой” төсөл нь нэн онцлог бөгөөд манай улсаас дэлхийд нэрээ таниулах олон бизнесийн түүчээ нь юм.

Өнгөрсөн хугацаанд бидний хүрсэн ололт амжилтаас та бүхэнтэй хуваалцъя.

- “Оюу толгой” нь уул уурхайн салбартаа аюулгүй ажиллагааны сайн үзүүлэлтээр тэргүүлж байна. Манай ажиллагсад төдийгүй бидний хамтран ажилладаг гэрээт байгууллагын ажиллагсад дэлхийн түвшинд хүрсэн аюулгүй ажиллагааны гүйцэтгэлтэй бүйг дээрх жишээ харуулж байна.
- Баяжуулах үйлдвэр ажиллаж эхэлснээс гурван жил хүрэхгүй хугацаанд олон улсын зах зээлд 3 сая орчим тонн зэсийн баяжмал үйлдвэрлэн нийлүүлээ.

- “Оюу толгой” нь Монгол Улсын топ татвар төлөгчдийн эхний байрт тогтмол орж байна.
- Гүний уурхайн ашиглалтанд орсноор “Оюу толгой” нь дэлхийн зэсийн салбарын хамгийн чухал төслүүдийн нэг болно.
- Гүний уурхайн төслийн санхүүжилт нь салбарын хэмжээнд хамгийн томоохонд тооцогдох ба дэлхийн олон орноос санхүүжилт босгосон нь Монгол Улсын гурав дахь хөршийн бодлого амьдрал дээр биеллээ олсны нэгээхэн илрэл билээ.

Миний ярьсан эдгээр баримт жишээ ямар учир холбогдолтой билээ гэсэн асуулт танд төрсөн үү?

Миний хувьд “Оюу толгой”-н амжилт нь Монголын амжилт гэж боддог. Учир юу гэвэл:

- “Оюу толгой” нь дэлхийтэй нягт холбогдсон Монгол компани.
- Бид Монгол зэсийг дэлхийд хүргэж, гэрлийн шил, гар утас, хиймэл дагуулыг бүтээлцэж, Монгол зэс хүн төрөлхтөний амьдралд үл мөрөө үлдээж байна.
- Энэ амжилтыг ил уурхай, баяжуулах үйлдвэр, гүний уурхайн төсөлд ажиллаж буй 10,000 Монгол хүн нэг бүр хамтдаа бүтээж байна.
Энэ амжилтыг Монгол орны өнцөг булан бүрт байгаа ханган нийлүүлэгч, түншүүд та бүхэнтэй хамтран бүтээж байна.

Өнөөдөр бид хамтдаа өнгөрснөө харж, ирээдүйгээ хэлэлцэх болно.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

---ТӨГСӨВ---